



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 18 сарын 23 өдөр

Дугаар А/800

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны Мал өвөлжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 419 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019-2020 оны мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд хил залгаа гадны аймгуудын сумдуудад оторлож байгаа малчдад төрийн болон нийгмийн үйлчилгээг тухайн сумдаас үзүүлэхэд зориулж олгох 10.000.000 (арван сая) төгрөгийг нэгдүгээр хавсралтаар,

2. Отроор өөр аймаг суманд өвөлжиж байгаа малчдын малыг тоолоход шаардлагатай байгаа нэмэлт хөрөнгө 8.200.000 (найман сая хоёр зуу) төгрөгийг хоёрдугаар хавсралтаар тус тус олгосугай.

3. Улсын нөөцөөс сумдад хуваарилсан өвс тэжээлийг хүргэх тээврийн зардалд 13.639.500 (арван гурван сая зургаан зуун гучин есөн мянга таван зуу), отрын малчдад олгосон эмийн багцад зарцуулсан 8.950.600 (найман сая есөн зуун тавин мянга зургаан зуу) төгрөг, нүүрсний үнэ ажлын хөлс, тээврийн зардалд 7.537.950 (долоон сая таван зуун гучин долоон мянга есөн зуун тавь), аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газарт отрын малчдыг эргэх, шатахууны зардалд 1671950 (нэг сая зургаан зуун далан нэгэн мянга есөн зуун тавь) төгрөгийг тус тус зарцуулсугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардлагатай 50.000.000 (тавин сая) төгрөгийг Засгийн газрын 2019 оны 419 дүгээр тогтоолоор хуваарилсан хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 23 ны өдрийн 4800 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ХИЛ ЗАЛГАА ГАДНЫ АЙМГУУДЫН СУМДУУДАД ӨТӨРЛОЖ
БАЙГАА МАЛЧДАД ТӨРИЙН БОЛОН НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ
ҮЗҮҮЛЭХЭД ЗОРИУЛЖ ОЛГОХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

д/д	Аймаг сум	Мөнгөн дүн сая/төг
1	Булган аймгийн Дашинчилэн сум	3,0 сая
2	Булган аймгийн Баяннуур сум	2,0 сая
3	Төв аймгийн Эрдэнэсант сум	3,0 сая
4	Төв аймгийн Баянхангай сум	2,0 сая
	ДҮН	10.0 сая

--oOo--

Аймгийн Засаг даргын 2019 оны 12
дугаар сарын 28-ны өдрийн 1700 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ОТРООР ӨӨР АЙМАГ СУМАНД ӨВӨЛЖИЖ БАЙГАА
МАЛЧДЫН МАЛЫГ ТООЛОХОД ШААРДЛАГ ТАЙ
БАЙГАА НЭМЭЛТ ХӨРӨНГӨ

д/д	Сумдын нэр	Хуваарилсан хөрөнгийн хэмжээ
1	Баян-Өндөр	1,2 сая
2	Бүрд	1,0 сая
3	Баянгол	0,5 сая
4	Есөнзүйл	1,0 сая
5	Өлзийт	1,2 сая
6	Зүүнбаян-Улаан	0,5 сая
7	Сант	1,0 сая
8	Тарагт	0,5 сая
9	Хужирт	0,5 сая
10	Хархорин	0,5 сая
11	Арвайхээр	0,3 сая
	ДҮН	8,2 сая

--oOo--